




ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ (2018 оны 05 сард)




2018.06.11

ᠳᠣᠷᠨᠣᠭᠣᠪᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢ ᠶ᠋ᠢ
ᠨᠢᠶᠢᠭᠡᠮ, ᠡᠳᠢᠶ᠋ᠨ ᠵᠠᠰᠭᠢᠶ᠋ᠨ ᠪᠠᠶᠳᠠᠯ
(2018 оны 05 сард)

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД



860



408

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд




Өмнөх оны
мөн үе

52.1%↓



Өмнөх
Сараас

119↑



133 иргэн ажилд
зуучлагдан оржээ

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2018 оны 5 сарын эцэст 860 болсны 833 (96.8%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 27 (3.2%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна. Нийт ажилгүй иргэдийн 408 (47.4 %) нь эмэгтэйчүүд байна.


Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 790 (52.1 %) хүнээр буурч, өмнөх сараас 119(16.1%) хүнээр өссөн байна.

Хөдөлмөрийн хэлтэст 2018 оны 05-р сард 1074 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 133 иргэн ажилд зуучлагдан орж, 98 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД



Бүртгэлтэй ажил хайгч иргэд, боловсролын түвшнээр, 2018 оны 05 сард





ЭРҮҮЛ МЭНД



Дорноговь аймгийн хэмжээнд 2018 оны 05 сард 563 эх амаржиж, 565 хүүхэд шинээр мэндэлжээ. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 45(8.7%)-оор, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 42(8.0%)-өөр, 160 хүн нас барсан нь 13(8.8%)-аар тус тус өссөн байна.



Нялхсын эндэгдэл 8 байгаа нь өмнөх оны мөн үеэс хувиар 60.0 өсчээ.



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй




Халдварт өвчний 306 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 141(31.5%)-ээр буурчээ.



Халдварт өвчний тохиолдол буурахад сүрьеэ 2.4 хувь, трихоминиаз 20.0 хувь, тэмбүү 24.6 хувь, вирус гепатит 66.7 хувиар, бусад төрлийн өвчин 63.1 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

ЭРҮҮЛ МЭНД

Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2018 оны 05 сард





НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

01

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 05 сард 13009.5 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2148.5(19.8%) сая төгрөгөөр өссөн байна.

02

Нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 05 сард өмнөх оны мөн үеэс 2148.5 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 1587.2(24.1%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сан 164.7(24.4%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 179.8(24.1%) сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

03

Нийгмийн даатгалын сангийн зарлага 17953.0 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 2327.2 (14.9%) сая төгрөгөөр өссөн байна.

04


Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 13162.5(73.3%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 2699.7(15.0%) сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 1041.4(5.8%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 729.6(4.1%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 319.8(1.8%) сая төгрөгийг зарцуулжээ.

05

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2018 оны эхний 05 сард нийгмийн халамжийн сангаас 19940 иргэнд 3339.1 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ

ГЭМТ ХЭРЭГ

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, үйлдэгдсэн цагаар



Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр оны эхний 05 сарын байдлаар 251 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 25 (9.1%)-оор буурсан байна.

Өмнөх оны мөн үеэс нийт гэмт хэрэг буурахад хүний амины гэмт хэрэг 1 (10.0%)-ээр, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 8(12.7%)-аар, мал хулгайлах гэмт хэрэг 4(16.0%)-өөр, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчсөн гэмт хэрэг 4(14.8%)-аар, бусад гэмт хэрэг 1(50.0%)-ээр буурсан нь голлон нөлөөлөв.



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 380.4 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 715.9 (65.3) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 239.5 (63.0 %) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.



МӨНГӨ, ЗЭЭЛ

Хадгаламжийн үлдэгдэл, сая.төг



2017 I-V

67720.8

2018 I-V

89726.0

Зээлийн өрийн үлдэгдэл, сая.төг



2017 I-V

182335.3

2018 I-V

223656.5

-Иргэдийн мөнгөн хадгаламж 89.7 тэрбум төгрөг болж

22.0 тэрбум ↑

- Нэг хадгаламж эзэмшигчдэд 1305.0 мянган төгрөг

288.2 мян.төг ↑

- Нэг хүнд дундажаар 1315.6 мянган төгрөг болж

298.8 мян.төг ↑

- Хадгаламж эзэмшигчийн тоо 68.8 мянган хүн болж

2.2 % ↑

-Зээлдэгчийн тоо 29.2 мянган хүн болж

3.0 % ↑


- Зээлийн өрийн үлдэгдэл 223.6 тэрбум болж

41.3% ↑




МӨНГӨ, ЗЭЭЛ

ЗЭЭЛ, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2018.05-р сард



Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2018.05-р сард



ТӨСӨВ, САНХҮҮ



2018 оны 05 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 11464.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 101.4 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 43.3 хувиар өссөн байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 72.0 хувийг татварын, 28.0 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн орлого, сая төг

7998.8 11464.1

2017 I-V


2018 I-V

Орон нутгийн төсвийн зарлага, сая төг

24794.8 21981.7

2017 I-V

2018 I-V



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 05-р сард өмнөх сараас 0.4 хувиар өсч, харин өмнөх оны мөн үеэс 3.0 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 05 дугаар сард өмнөх сараас 0.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа усны бүлэг 1,2 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодисын бүлэг, 0.4 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 0.9 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 0.7 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 1.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 3.0 хувиар өсөхөд: хүнсний бараа, ундаа усны бүлэг 5.2 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлэг 7.8 хувь, орон сууц, ус цахилгаан, түлшний бүлэг 0.3 хувь, эм, тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 119.6 хувь, тээврын бүлэг 4.1 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын барааны бүлэг 9.7 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлэг 2.6 хувиар тус тус нэмэгдсэн байна.






АЖ ҮЙЛДВЭР



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2018 оны эхний 05 сард 72542.4 сая төгрөг төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 44234.4(2.3 дахин) сая төгрөгөөр өслөө.




Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2018 оны эхний 05 сард 112477.0 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 60.7 хувиар өслөө.




АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлт салбараар



Аж үйлдвэрийн нийт борлуулалт салбараар





АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт, дэд салбараар, оны үнээр, сая төгрөг

Салбар	2016 I-V	2017 I-V	2018 I-V	2017 I-V 2018 I-V
	сая.төг			хувь
Дүн	7462.9	35308.0	79542.4	2.3 ²
Уул уурхай олборлох аж үйлдвэр	1128.1	24145.4	40253.2	166.7
Нүүрс олборлолт	1128.1	24145.4	40253.2	166.7
Бусад ашигт малтмал олборлолт				
Боловсруулах аж үйлдвэр	513.9	7508.1	35542.3	4.7 ²
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	341.0	1012.2	561.6	55.5
мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	17.2	652.5	270.0	41.4
сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	46.1	83.5	66.7	79.9
хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	277.7	276.2	224.9	81.4
Хувцас үйлдвэрлэл	25.2	17.8	22.9	128.7
Гутал үйлдвэрлэл	6.4	8.0	2.4	30.0
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	21.1	17.7	32.6	184.2
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	0.1	0.2	0.1	
Боловсруулах үйлдвэрийн бусад	120.1	6452.2	34922.7	5.4 ²
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	5820.9	3654.5	3746.9	102.5
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	5023.2	2661.5	2933.7	110.2
Ус ариутгал, усан хангамж	797.7	993.0	813.2	81.9



СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

Статистикийн лавлах
1900-1212

Статистикийн мэдээллийн
нэгдсэн сан
www.1212.mn

Дорноговь аймгын
Нутгийн
удирдлагын
ордоны 106 тоот

 Статистик мэдээлэл

 @statistic_mn

www.nso.mn сайтын
Хэрэглэгчийн бүртгэлд
бүртгүүлж мэдээлэл авах

